



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/203/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	22
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	22
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	22
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХК	Хувьцаат компани
ТӨХК	Төрийн өмчит Хувьцаат компани
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.08.25 № 04/68
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА А.НЯМСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар шилжих үлдэгдлээр санхүүжүүлсэн хөрөнгийн зардлаас 21,890.4 мянган төгрөгийн зардлыг хөрөнгө оруулалтын шинж чанартай үйл ажиллагаанд зарцуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл, гэрээ байгуулах болон ажлын явцын тайлангүй худалдан авах ажиллагааны журмыг мөрдөөгүйтэй холбоотой 152,484.6 мянган төгрөгийн, нийт 174,375.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 32 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас хэрэгжилт 83,8 %-тай дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн "Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай" 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 13-д "орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх" төсөл арга хэмжээний хүрээнд 2 байр нийлүүлэхээр аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Аргалант сумын Засаг дарга, иргэнтэй гуравласан гэрээ байгуулж, Аймгийн засаг даргаар батлуулсан байна.

Гуравласан гэрээний 3-д заасны дагуу ажлын явцын тайлан, гэрээ дүгнэсэн баримтгүйгээр 1 дэх болон 2 дахь шатны 80 хувийн санхүүжилтэд 80,000.0 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн данснаас олгосон байна.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газар нь 3,580.1 мянган төгрөгийн 1165 ширхэг үндсэн хөрөнгө Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 17-д нийцээгүй, 52,897.1 мянган төгрөгийн 36 нэр төрлийн бараа материалыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 12-д нийцүүлэн ангилж бүртгээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	137,991,141.36	204,156,112.06
33	АВЛАГА	51,104,058.20	109,040,500.00
33500	Бусад авлага	51,104,058.20	109,040,500.00
33510	Байгууллагаас авах авлага	51,104,058.20	109,040,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	86,887,083.16	95,115,612.06
35400	Хангамжийн материал	83,387,083.16	91,615,612.06
35410	Бичиг хэргийн материал	1,722,690.00	2,012,100.00
35420	Аж ахуйн материал	10,841,240.00	15,193,639.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,984,000.00	2,984,000.00
35440	Түлш, шатах тослох материал	618,580.00	159,300.00
35450	Барилгын засварын материал	2,472,290.00	2,472,290.00
35470	Бусад хангамжийн материал	64,748,283.16	68,794,283.06
35600	Мал амьтад	3,500,000.00	3,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,530,163,381.36	2,435,882,962.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,530,163,381.36	2,435,882,962.88
39200	Биет хөрөнгө	1,877,198,214.65	1,783,353,796.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,432,702,091.26	2,439,702,091.26
39202	Хуримтлагдсан элэгдэл	-975,278,749.22	-1,068,848,739.98
39203	Авто-тээврийн хэрэгсэл	257,848,032.00	257,848,032.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-108,228,516.16	-129,903,274.65
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	616,064,829.73	654,377,849.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-425,497,293.51	-474,050,458.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,405,916.00	82,405,916.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50,702,025.09	-60,449,683.86
39209	Зам, гүүрийн байгууламж	41,000,000.00	41,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-41,000,000.00	-41,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	288,872,660.00	337,094,660.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-240,988,730.36	-254,822,596.32
39300	Биет бус хөрөнгө	652,965,166.71	652,529,166.75
39301	Програм хангамж	3,510,000.00	3,510,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,778,833.29	-3,214,833.25
39303	Бусад биет бус хөрөнгө	652,234,000.00	652,234,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,668,154,522.72	2,640,039,074.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	1,148,056.17
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	1,148,056.17
41300	Өглөг	0	1,148,056.17
41360	Бусад өглөг	0	1,148,056.17
41361	Байгууллагад төлөх өглөг	0	1,148,056.17
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,668,154,522.72	2,638,891,018.77
51	Засгийн газрын хувь оролцоо	2,668,154,522.72	2,638,891,018.77
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,377,154,433.19	1,377,154,433.19
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,377,154,433.19	1,377,154,433.19
51200	Хуримтлагдсан үр дүн	1,148,582,769.85	1,119,319,265.90
51210	Өмнөх үеийн үр дүн	960,355,030.06	1,148,582,769.85
51220	Тайлант үеийн үр дүн	188,227,739.79	-29,263,503.95
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	142,417,319.68	142,417,319.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,668,154,522.72	2,640,039,074.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	744,086,255.90	856,332,416.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	225,514,992.00	16,841,399.00
120	Нийтлэг татварын бус орлого	225,514,992.00	16,841,399.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	222,011,192.00	16,841,399.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,503,800.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	518,571,263.90	839,491,017.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,644,163.90	149,801,817.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	29,644,163.90	149,801,817.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	488,927,100.00	689,689,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт ба	488,927,100.00	524,689,200.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	0	165,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	555,750,016.11	885,595,920.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	544,181,245.43	793,947,136.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	500,864,824.95	742,669,310.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	183,653,657.80	346,076,449.26
210101	Үндсэн цалин	149,071,488.46	239,087,959.61
210102	Нэмэгдэл	24,766,670.40	75,037,081.65
210104	Урамшуулал	8,598,582.40	31,951,408.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,244,327.27	46,790,775.57
210201	Тэтгэврийн даатгал	17,403,161.15	34,398,673.93
210202	Тэтгэмжийн даатгал	1,873,079.45	3,429,582.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,441,530.36	2,748,046.40
210204	Ажилгүйдлийн даатгал	308,072.44	557,800.08
210205	Эрүүл мэндийн даатгал	3,218,483.87	5,656,673.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,771,110.00	89,836,237.77
210301	Гэрэл, цахилгаан	6,051,300.00	8,244,069.77
210302	Түлш, халаалт	57,002,010.00	81,592,168.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,625,672.80	34,571,345.20
210401	Бичиг хэрэг	2,555,090.00	6,978,770.00
210402	Тээвэр, шатахуун	18,895,982.80	26,090,475.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,174,600.00	1,502,100.00
2105	Нормативт зардал	950,100.00	1,832,800.00
210502	Хоол, хүнс	950,100.00	1,832,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	5,474,109.70
210602	Тавилга	0	2,292,109.70
210604	Урсгал засвар	1,500,000.00	3,182,000.00
2107	Томиллолт, зочны зардал	2,876,000.00	5,436,400.00
210702	Дотоод албан томилолт	2,876,000.00	5,436,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур	23,092,665.35	4,404,173.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний тө	22,119,775.35	3,855,694.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	233,068.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	219,890.00	315,411.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	178,151,291.73	208,247,020.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,307,361.00	20,431,582.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	165,843,930.73	187,815,438.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,316,420.48	51,277,825.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,106,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,106,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох т	38,210,420.48	50,277,825.87
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,210,420.48	50,277,825.87
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,568,770.68	91,648,784.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,568,770.68	91,648,784.00
221001	Их засвар	11,568,770.68	40,809,000.00
222001	Тоног төхөөрөмж	0	3,799,800.00
223001	Бусад хөрөнгө	0	47,039,984.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	188,336,239.79	-29,263,503.95
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	188,227,739.79	-29,263,503.95

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	518,571,263.90	839,491,017.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	518,571,263.90	839,491,017.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,644,163.90	149,801,817.90
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,644,163.90	149,801,817.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	488,927,100.00	689,689,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	488,927,100.00	524,689,200.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	0	165,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	392,313,902.90	672,846,637.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	392,313,902.90	672,846,637.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	348,723,482.42	621,568,811.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	184,960,362.16	348,614,556.26
210101	Үндсэн цалин	150,366,870.65	228,419,748.06
210102	Нэмэгдэл	25,994,909.11	92,819,530.96
210104	Урамшуулал	8,598,582.40	27,375,277.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,970,674.57	44,245,675.17
210201	Тэтгэврийн даатгал	15,046,111.04	30,088,299.26
210202	Тэтгэмжийн даатгал	1,612,069.28	3,555,817.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,242,801.81	2,925,929.29
210204	Ажилгүйдлийн даатгал	268,528.80	711,085.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,801,163.64	6,964,544.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,714,900.00	89,423,668.00
210301	Гэрэл, цахилгаан	6,051,300.00	7,161,500.00
210302	Түлш, халаалт	56,993,600.00	81,592,168.00
210303	Цэвэр, бохир ус	670,000.00	670,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,000,642.00	15,614,603.00
210401	Бичиг хэрэг	1,463,000.00	2,177,860.00
210402	Тээвэр, шатахуун	8,257,642.00	8,789,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,280,000.00	2,223,920.00
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	2,423,223.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	2,300,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	2,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,876,000.00	5,436,400.00
210702	Дотоод албан томилолт	2,876,000.00	5,436,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,239,413.69	7,556,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,266,523.69	7,066,694.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	233,068.00
210803	Даатгалын үйлчилгээ	282,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	219,890.00	256,918.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,461,490.00	108,377,228.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,461,490.00	108,377,228.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,590,420.48	51,277,825.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,380,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,380,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	38,210,420.48	50,277,825.87
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,210,420.48	50,277,825.87
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	126,257,361.00	166,644,380.70
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	126,257,361.00	166,644,380.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	126,257,361.00	166,644,380.70
2200	Дотоод эх үүсвэрээр	126,257,361.00	166,644,380.70
221001	Их засвар	67,763,930.00	20,678,649.00
222001	Тоног төхөөрөмж	0	3,380,000.00
223001	Бусад хөрөнгө	58,493,431.00	19,749,676.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	122,836,055.70
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-126,257,361.00	-166,644,380.70
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,377,154,433.19	142,417,319.68	960,355,030.06	2,479,926,782.93
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,377,154,433.19	142,417,319.68	960,355,030.06	2,479,926,782.93
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	188,227,739.79	188,227,739.79
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,377,154,433.19	142,417,319.68	1,148,582,769.85	2,668,154,522.72
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,377,154,433.19	142,417,319.68	1,148,582,769.85	2,668,154,522.72
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,377,154,433.19	142,417,319.68	1,148,582,769.85	2,668,154,522.72
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-29,263,503.95	-29,263,503.95
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,377,154,433.19	142,417,319.68	1,119,319,265.90	2,638,891,018.77

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны к	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
II НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		20,923,382.00	126,179,654.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,923,382.00	126,179,654.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,543,382.00	126,179,654.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	24,031,890.60
210101	Үндсэн цалин	00.00	1,821,052.60
210102	Нэмэгдэл	00.00	22,210,838.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	3,209,475.17
210201	Тэтгэврийн даатгал	00.00	2,183,699.26
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	272,917.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	299,529.29
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	54,585.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	398,744.62
2104	Хангамж, бараа материалын зардал	1,026,342.00	561,060.00
210401	Бичиг хэрэг	00.00	177,860.00
210402	Тээвэр, шатахуун	1,026,342.00	383,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,517,040.00	98,377,228.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,517,040.00	98,377,228.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,380,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,380,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,380,000.00	00.00
I ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		20,923,382.00	126,179,654.67
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,923,382.00	126,179,654.67
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,923,382.00	107,645,852.77
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	18,533,801.90
IV НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		00.00	00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00	00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	786,642,600.00	663,033,537.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	509,689,200.00	496,389,156.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	508,689,200.00	495,389,156.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	328,289,500.00	324,582,665.66
210101	Үндсэн цалин	283,385,800.00	226,598,695.46
210102	Нэмэгдэл	44,903,700.00	70,608,692.96
210104	Урамшуулал	0	27,375,277.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,036,200.00	41,036,200.00
210201	Тэтгэврийн даатгал	27,904,600.00	27,904,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,282,900.00	3,282,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,626,400.00	2,626,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	656,500.00	656,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,565,800.00	6,565,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,048,400.00	89,423,668.00
210301	Гэрэл, цах илгаан	7,161,500.00	7,161,500.00
210302	Түлш, халаалт	87,216,200.00	81,592,168.00
210303	Цэвэр, бохир ус	670,700.00	670,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,438,400.00	15,053,543.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,134,400.00	8,406,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,604,000.00	2,223,920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,700,000.00	2,423,223.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,300,000.00	2,300,000.00
210604	Урсгал засвар	2,300,000.00	2,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,752,400.00	5,436,400.00
210702	Дотоод албан томилолт	5,752,400.00	5,436,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,824,300.00	7,556,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,500,000.00	7,066,694.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	233,068.00
210803	Даатгалын үйлчилгээ	325,000.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	479,300.00	256,918.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	170,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	10,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	10,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	276,953,400.00	166,644,380.70
221001	Их засвар	180,000,000.00	88,284,075.00
222001	Тоног төхөөрөмж	33,453,400.00	32,574,420.00
223001	Бусад хөрөнгө	63,500,000.00	45,785,885.70
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	786,642,600.00	663,033,537.36
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	524,689,200.00	498,033,537.36
320001	Орон нутгийн төсвөөс	524,689,200.00	498,033,537.36
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	261,953,400.00	165,000,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	261,953,400.00	165,000,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	43	43
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	19
620001	Удирдах ажилтан	5	5
620002	Гүйцэтгэх ажилтан	9	7
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	4	4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	19
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	4	4

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 32 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас хэрэгжилт 83,8 %-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн А/01 тоот тушаалаар байгууллагын бүтэц, орон тоо, цалингийн санг баталсан байна. Удирдах 3 ажилтан, төрийн захиргааны 8, төрийн үйлчилгээний 4 албан хаагч, гэрээт 4 ажилтан, багийн засаг дарга 2, нийт 21 орон тоог баталж, 19 хүнтэй үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аргалант сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу төрийн байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй үзүүлж сумын үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг сайжруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж ажилласан байна.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотой өөрчлөлтийг нэмж тусган мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2013 онд аймгийн хэмжээнд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй бөгөөд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэж, 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02/51 албан тоотоор Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт, шинэчлэлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,115.4 мянган төгрөгөөр буюу 1,1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Авлага	51,104.0	109,040.5	57,936.5
Бараа материал	86,887.1	95,115.6	8,228.5
Үндсэн хөрөнгө	2,530,163.4	2,435,883.0	-94,280.4
Нийт хөрөнгө	2,668,154.5	2,640,039.1	-28,115.4
Өр төлбөр	0.0	1,148.1	1,148.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,668,154.5	2,638,891.0	-29,263.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,668,154.5	2,640,039.1	-28,115.4

Дээрх хүснэгтээс харахад, Авлага дансны үлдэгдэл 109,040.5 мянган төгрөг болж 57,936.5 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэхээр 80 хувийн санхүүжилтэд нэмэлт санхүүжилтийн данснаас 80,000.0 мянган төгрөг шилжүүлж, авлагаар бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 86,887.1 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 44,283.8 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, тайлант онд зарцуулсан 36,055.2 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгож, бараа материалын эцсийн үлдэгдэл 95,115.6 мянган төгрөг байна.

Бараа материалын үлдэгдэл 95,115.6 мянган төгрөг болж, 8,228.5 мянган төгрөгөөр өссөн нь өвөлжилтийн бэлтгэлд 4,046.0 мянган төгрөгийн ногоон тэжээл, камерын засварт

2,000.0 мянган төгрөгийн сэлбэг, үндсэн хуулийн мэдлэг дээшлүүлэх 1,800.0 мянган төгрөгийн ном зэрэг аж ахуйн материалууд авсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 2,530,163.4 мянган төгрөг, тайлант онд шилжих үлдэгдлээс 122,836.0 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авч, ОНХС-аас бэлтгэсэн 16,488.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээж авсан орлогоор бүртгэж, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,435,883.0 мянган төгрөг болсон байна.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 94,280.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд шилжих үлдэгдлээр бэлтгэсэн 45,789.4 мянган төгрөгийн хөрөнгийг бусад байгууллагад шилжүүлсэн (сумын ИТХ-д 2,292.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил, соёлын төвд 22,599.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тавилга эд хогшил, цэцэрлэгт 19,367.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил) болон тайлант онд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 187,815.4 мянган төгрөг гарсан нь нөлөөлсөн байна.

Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн 65.5 мянган төгрөгийн, гэрэл цахилгааны зардлын 1,082.6 мянган төгрөгийн өглөг шинээр үүссэнээс өр төлбөр дансны үлдэгдэл 1,148.1 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,638,891.0 мянган төгрөг болж 29,263.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 493,379.7 мянган төгрөг, нийт зарлагыг 493,379.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 199,107.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2023 оны урсгал зардлын төсвийг 692,487.2 мянган төгрөгөөр сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 01 тоот тогтоолоор баталсан байна.

Энэ нь шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 180,000.0 мянган төгрөгөөр, урсгал зардалд 16,407.5 мянган төгрөгөөр, хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээнд 2,700.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 01 тоот тогтоолоор тайлант оны батлагдсан төсөв 692,487.2 мянган төгрөгийг 94,155.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 786,642.6 мянган төгрөгөөр тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага гэсэн 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг орон нутгийн төсвөөс 524,689.2 мянган төгрөгөөр, төсвийн шилжих үлдэгдлийн эх үүсвэрээс 261,953.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр 697,321.1 мянган төгрөг буюу санхүүжилтийг 88,7 хувь олгож, оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 26,655.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 663,033.5 мянган төгрөг буюу 84,3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлаас 7,100.1 мянган төгрөг, баг хорооны үйл ажиллагааны зардлаас 5,923.2 мянган төгрөг, бусад зардлаас 13,355.6 мянган төгрөг, хур хог хаягдал орчны бохирдлыг бууруулах зардлаас 276.8 мянган төгрөг, нийт 26,655.7 мянган төгрөгийг дутуу зарцуулж, орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	410,681.1	403,581.0	7,100.1	98.3%
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	50,365.5	50,365.5	0.0	100.0%
3	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80106- Баг, хорооны үйл ажиллагааны зардал	34,942.6	29,019.4	5,923.2	83.0%
4	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,000.0	1,000.0	0.0	100.0%
5	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80918-Бусад	276,953.4	166,644.4	110,309.0	60.2%
6	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 81102- Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	5,000.0	0.0	100%
7	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 82801- Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0.0	100%
8	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага 82212- Хур хог хаягдал, орчны бохирдол	2,700.0	2,423.2	276.8	89.8%
	Дүн	786,642.6	663,033.5	123,609.1	84.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас төрийн захиргааны албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэлд 15,483.0 мянган төгрөг, төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөрт 100,000.0 мянган төгрөг, малын тооллогын зардалд 565.0 мянган төгрөг, өвс тэжээлийн нөөцийн санхүүжилт 6,499.2 мянган төгрөг, өмнөх жилийн төвлөрүүлсэн нэмэлт санхүүжилтийн орлого 8,720.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын орлогод 18,533.8 мянган төгрөг, нийт 149,801.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 126,179.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 23,622.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлын зарцуулалтыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт / мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
---	----------	------------------	--------------	------------------	-----------------	------------

1	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлэх	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр 84.3 %	783,942.6	660,610.3
2	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2023.01.01-2023.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хэрэгжүүлнэ.	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөр 89.8%	2,700.0	2,423.2

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны тайлант хугацаанд Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага /70106/ хөтөлбөр 84,3 хувиар, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага /71411/ хөтөлбөр 89,8 хувиар хэрэгжүүлсэн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний www.tender.gov.mn-д 20 бараа, ажил үйлчилгээг худалдан авах төлөвлөгөөг байршуулсан байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтаар 1 ажил, тендер шалгаруулалтын онцгой журмаар 3 ажил, ерөнхий гэрээгээр 1 худалдан авах ажиллагааг хэрэгжүүлж тайлагнасан байна.

Шууд худалдан авалт хийхдээ харьцуулалтын аргаар худалдан авалт зохион байгуулсан хурлын тэмдэглэл байхгүй, шийдвэр гаргасан байдал тодорхойгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02/51 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлага 524,689.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу

7,870.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,902.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг зөрчиж төсвийн хөрөнгөөр биеийн тамирын хувцас 1,080.0 мянган төгрөгөөр худалдан авсан, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг хэрэгжүүлэлгүй байгууллагын эзэмшилд байгаа тээврийн хэрэгслүүд ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй зөрчил байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад тендер худалдан авалтын 10, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12, зарлагын 43 мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 20 шийдвэрийг байршуулсан байна.

Шилэн дансанд байршуулбал зохих 159 мэдээллээс, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 16 мэдээлэл, хугацаандаа байршуулсан 141 мэдээлэл, хуулийн хэрэгжилт 94,9 хувьтай байна

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн.

Аргалант сумын Засаг даргын тамгын газрын дарга нь санхүүгийн тайлангийн аудитын завсрын үе шатны асуудлын бүртгэлтэй танилцаад санал тайлбар бичээгүй, гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулж өгөөгүй, хэрэгжилтийг гаргаж ирүүлээгүй тул биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж, үр дүнг аудитын тайланд тусгасан болно.

Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 4 зөвлөмж, 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, эд хөрөнгийн тооллогыг явуулах талаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Шилэн дансны цахим системд мэдээллийг бүрэн оруулах зөвлөмж хэрэгжсэн, харин шууд худалдан авалт хийхдээ хамтын шийдвэрийг үндэслэх, худалдан авах ажиллагаанд эрх бүхий байгууллагын (өмч хамгаалах байнгын зөвлөл) хурал болон техникийн комиссын шийдвэр гаргаж байх, шилжих үлдэгдлээс санхүүжүүлэх хөрөнгийн зардлаас хөрөнгө оруулалтын шинжгүй зардалд зарцуулсан зөрчлүүдийг арилгах, санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор өгөгдсөн 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 02/20, 02/21 тоот албан бичгүүдээр ирүүлж, <http://fas.audit.mn/> системд хэрэгжилтийг мэдээлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	6,188.9	3	6,188.9	100%
Албан шаардлага	2	47,200.0	2	47,200.0	100%
Зөвлөмж	2	135,752.7	2	135,752.7	100%
Нийт дүн	7	189,141.6	7	189,141.6	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд байгаа хөрөнгийн ангиллын байдал, төрийн өмчид бүртгэлээр тавих хяналтыг хэрхэн сайжруулсан байдлыг дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 51,425.9 мянган төгрөгийн 2 алдаа¹, 162,135.4 мянган төгрөгийн 11 зөрчил² илэрсний 89,650.8 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 64,131.1 мянган төгрөгийн 2 зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага өгч, 8,371.5 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 51,425.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг зөрүүтэй оруулж, төсвийг татан төвлөрүүлсэн 50,277.8 мянган төгрөгөөр тохируулга хийгээгүй, нэмэлт санхүүжилтийн тайланг өмнөх үеийн тоон үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлэхүйц байх зарчмыг хангаж бэлтгээгүй алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4.1-д “үйл ажиллагааны үр дүнгийн тайлан”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-д “орлогын дэлгэрэнгүй тайлан”, 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

2. Нийгмийн даатгалын шимтгэлийн 65.4 мянган төгрөгийн, гэрэл цахилгааны 1,082.6 мянган төгрөгийн, нийт 1,148.0 мянган төгрөгийн өглөгийг тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “тасалбар болголт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

5.1 Төлбөрийн акт

1. Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Б/02 тоот захирамж, Аргалант сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/01 тоот захирамжийг үндэслэн улс төрийн 4 албан тушаалтанд орон нутгийн нэмэгдэлд 7,932.0 мянган төгрөг олгосон зөрчил байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 -д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтооно гэж заасны дагуу шийдвэрлэв.

2. Байгууллагын төсвийг зохистой удирдаагүй, авлага, өр төлбөр үүсгэн төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй ажилласан Тамгын газрын даргад 12 дугаар сард 2 дахь удаагийн үр дүнгийн мөнгөн урамшуулалд 638.8 мянган төгрөг олгосон зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим”, заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 -д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтооно гэж заасны дагуу шийдвэрлэв.

3. Байгууллагын төсвийн хөрөнгөөр 1,080.0 мянган төгрөгийн биеийн тамирын 18 ширхэг хослол худалдан авсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “толилуулга”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.1-д “төрийн өмч хөрөнгийг үндэслэлгүйгээр бусдад хандивласан, үнэ төлбөргүй шилжүүлсэн” бол төлбөрийн акт тогтооно гэж заасны дагуу шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

1.Засаг даргын Тамгын газрын дарга нь 4 дүгээр улиралд шууд худалдан авалт хийх ажиллагаандаа эрх бүхий байгууллагын (өмч хамгаалах байнгын зөвлөл) хурал болон техникийн комиссын хамтын шийдвэр гаргаж харьцуулалт хийхгүйгээр 16 удаа хүчин төгөлдөр бус гэрээ байгуулж, 56,938.5 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д “хууль тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага өгнө гэж заасны дагуу шийдвэрлэв.

2. Дэмжих анхан шатны баримтгүй, үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж баталгаажуулаагүй, зарцуулалтын тайлангүй 7,174.6 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.

Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” албан шаардлага өгнө гэж заасны дагуу шийдвэрлэв.

3. Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд (27.24 м.кв, 29.14 м.кв 1 өрөө) 2 байр нийлүүлэх гэрээний 3-д заасны дагуу үндэслэх ажлын явцын тайлан, гэрээ дүгнэсэн баримтгүйгээр 1, 2 дахь шатны 80 хувийн санхүүжилтэд 80,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас олгосон зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т “төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 282 тоот тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.12-д “төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн зүйлийн 21.1 дэх заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д “хууль тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага өгнө гэж заасны дагуу шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бусад асуудал

1.1.Илрүүлэлт:

Байгууллагын эзэмшилд байгаа 21 газраас 19 газар бүртгэлтэй, бусад 2 газрыг данс бүртгэлд аваагүй, бүртгэлтэй газрын хэмжээснүүд тохирохгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “иргэдэд өмчлүүлснээс бусад газар”, 72 дугаар зүйлийн 72.4.1-д “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2.Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшилд байх газрыг данс бүртгэлд бүрэн авах

2. Хариуцлагыг сайжруулахтай холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Байгууллагын өмчид бүртгэлтэй авто тээврийн хэрэгслүүд нь ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2.Өгсөн зөвлөмж:

Байгууллагын өмчид бүртгэлтэй авто тээврийн хэрэгслүүдэд ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар авах

3. Хариуцлагыг сайжруулахтай холбоотой асуудал

3.1.Илрүүлэлт:

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй 4.325,5 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “цахим төлбөрийн баримтад үндэслэн бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрдүүлэх” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2.Өгсөн зөвлөмж:

Цахим төлбөрийн баримтад үндэслэн бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрдүүлэх

4. Төлөвлөлт, хяналт, удирдлагыг сайжруулахтай холбоотой асуудал

4.1.Илрүүлэлт:

Шилжих үлдэгдлийн эх үүсвэртэй хөрөнгийн зардлаас төсөл арга хэмжээнд зарцуулахдаа хөрөнгө оруулалтын шинжгүй зардалд 21,890.4 мянган төгрөг зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Ангилал”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу төлөвлөж, зарцуулах

5. Хариуцлагыг сайжруулахтай холбоотой асуудал

5.1.Илрүүлэлт:

Ногоон тэжээл худалдан авахаар Марс арвай ХХК-тай 4,046.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, төлбөр тооцоо хийхдээ хувь хүнд шилжүүлсэн зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.5.4-д “төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “тохиолдсон байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж Гэрээний дагуу бэлтгэн нийлүүлэгчид төлбөр тооцоог хийж байх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төсвийн хөрөнгөөр 1,080.0 мянган төгрөгөөр 18 ширхэг биеийн тамирын хослол худалдан авсан зөрчил байна.	1	1,080.0	1	1,080.0								
Байгууллагын төсвийг зохистой удирдаагүй, авлага, өр төлбөр үүсгэн ажилласан Тамгын газрын даргад 12 дугаар сард 2 дахь удаа мөнгөн урамшуулалд 638.8 мянган төгрөг олгосон зөрчил байна.	1	638.8	1	638.8								
Засаг даргын Тамгын газрын дарга нь 4 дүгээр улиралд шууд худалдан авалт хийхдээ 16 удаа хүчин төгөлдөр бус гэрээ байгуулж, 56,938.5 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил байна.	1	56,938.5			1	56,938.5						
Дэмжих анхан шатны баримтгүй, үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж баталгаажуулаагүй, зарцуулалтын тайлангүй 7,174.6 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил байна.	1	7,174.6			1	7,174.6						
Шилжих үлдэгдлийн эх үүсвэртэй Хөрөнгийн зардлаас хөрөнгө оруулалтын шинжгүй зардалд 21,890.4 мянган төгрөг зарцуулсан зөрчил байна.	1	21,890.4					1	21,890.4				
Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй 4.325,5 мянган төгрөгийн зөрчил байна.	1	4.325.5					1	4.325.5				

